

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.02.02

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар

Энэ сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэн 17 тогтоол баталлаа. Үүнд:

-Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны ажлын төлөвлөгөөг баталж, 2019 онд ахуйн зориулалтаар агнах барих амьтны тоо, 2019 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг тогтоож, 2019 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2015-2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайлан, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны тайлан мэдээллийг сонсож, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өглөө. Мөн үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, тээврийн хэрэгслийг шилжүүлэхийг зөвшөөрөх шийдвэрийг гаргаж, Шаамар сумын Эрүүл мэндийн төвийг Хүний гавьяат эмч, Төрийн шагналт, доктор, профессор Намжилын Даваацэрэнгийн нэрэмжит болгохоор шийдвэрлэж, Орхон сумын үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг 2019 оны 07 дугаар сард, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг 2019 оны 09 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлэх тухай асуудлыг шийдвэрлэж, .Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулж буй Монголын бурхан шашны Гандантэгчэнлин хийдийн харьяа Пандэлин хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгав.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс Олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог Сүхбаатар суманд 3, Мандал суманд 2, Сайхан суманд 2 байхаар тогтоосон.

Мөн Сэлэнгэ аймгийн харьяат зарим хүмүүсийг төрийн одон медалиар шагнуулах саналыг уламжлахаар тогтож, Орхон сумын иргэн Т.Доржтовууг Гавьяат механикжуулагч цол тэмдгээр, мөн сумын иргэн Д.Сумбааг Гавьяат тээвэрчин цол тэмдгээр шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлан хүргүүлэв.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Тус аймгийн Орхон, Сант, Мандал, Цагааннуур, Сайхан сумдад “Гахайн Африк мялзан” гоц халдварт өвчин оношлогдсонтой холбогдуулан аймгийн онцгой комисс хуралдаж “Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” захирамж гаргаж Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газрын хамтарсан шуурхай баг бүрэлдэхүүн тус сумдуудад ажилласан ба УМЭАЦТЛ-д илгээсэн дээжийн шинжилгээний хариуг үндэслэн Орхон, Мандал, Цагааннуур, Сант сумдад хорио цээрийн дэглэж тогтоосон. Уг ажилд 4 сумын нийт 25 өрхийн 443 толгой гахайг устгалд оруулж 21051 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг тусгай тоноглогдсон ДУК автомашинаар хийж гүйцэтгэсэн.

Лабораторийн оношлох, илрүүлэх, баталгаажуулах шижилгээнд нийт 13 дээж, үүнээс нян судлалын шинжилгээнд 5 эмгэгт дээж, АХЦБӨ, ям, нийлүүлгийн өвчнүүдийг оношлох шинжилгээг тус тус батлагдсан стандарт, арга зүйн дагуу хийсэн.

Үүнтэй холбогдуулан Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 1-р сарын 10-ны өдрийн “Гахайн африк мялзан өвчнөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг сумдад хүргүүлж, сумдын Хөдөө аж ахуйн тасгийн

мэргэжилтэн малын эмч, МЭҮН-ийн эмч нар иргэдэд тарааж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.

Сэлэнгэ аймгийн жилийн эцсийн малын тоо 1540036 толгой мал тоологдсон. Үүнд: тэмээ-483, адуу-97604, үхэр-216805, хонь-705874, ямаа-519270 байна. Үүнээс цэвэр эрлийз малын тоо 394101, цэвэр 151664, сайжруулсан 200576 толгой мал тоологдсон.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр тус аймгаас шалгарсан Улсын аварга малчин, Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланчдын шагналыг гардуулах арга хэмжээ боллоо. Үүнд:

1.“Улсын аварга малчин”-аар Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Баянцогт багийн малчин Хандын Батсүх, Хүдэр сумын Тарвагатай багийн малчин Намсрайн Цогнэмэх, Ерөө сумын хоёрдугаар багийн малчин Санжийн Түмэн-Өлзий

2.“Улсын аварга тариаланч хамт олон”-оор Сэлэнгэ аймгийн Баянгол сумын "Түмэн бут" ХХК, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Mo Mo Agro" ХХК

3.“Улсын аварга тариаланч”-аар Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэн Буянхишигийн Анхтөр, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Товхон хан” ХХК-ийн механикжуулагч Даваасүрэнгийн Алтанхуяг нарыг шалгарсан.

Нутгийн захиргааны байгууллагуудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг тооцон, аймгийн аваргуудыг шалгаруулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, ойн анги, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нартай 2019 онд хамтран ажиллах гэрээ байгуулан, ирэх онд баримталж ажиллах бодлого зорилтоо тодорхойлох зорилгоор “Сэлэнгэ аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн-2019” арга хэмжээг 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Зөвөгөөнд Эрүүл мэндийн яамны дэд сайд Л.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлтийн газрын захирал Ш.Одонбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Нямсүрэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Э.Эрдэнэбилэг, Байгаль орчин, аялал жуулалтын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар, Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зам ашиглалт, засварын хэлтсийн дарга Х.Оргил-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны ахлах ажилтан, ахлах комиссор Д.Цэнд-Аюуш, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Мөнхжаргал нар оролцож, орон нутгийн түвшинд анхаарах асуудлын талаараа чиглэл өгч, мэдээлэл хийлээ.

Энэ онд атар газар эзэмшсэний 60 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан “Атрын нутгийн амар мэнд” нэртэй нэвтрүүлэгийг аймгийн Засаг даргын Тамгын газар, МҮОНТ-тэй хамтран бэлтгэж, сар шинийн баярын өдрүүдэд гаргахаар боллоо.

VII жарны "Урвуулагч" хэмээх шарагчин гахай жилийн уламжлалт цагаан сарын баярыг тохиолдуулан аймгийн хэмжээний 85-аас дээш насны 400 гаруй ахмад настанд хүндэтгэл үзүүлж, аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардууллаа.

“Сэлэнгэ аймаг-Хөрөнгө оруулалт, эдийн засгийн чуулга уулзалт”-ын хүрээнд дэмжигдсэн төслүүдийн нэг болох аймгийн ЗДТГ-аас боловсруулсан “Цахим орчныг сайжруулах төсөл” төслийг дэмжин Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөтөлбөрийн газраас /GIZ/ дэмжин Герман Улсаас оруулж ирсэн Logitech брэндийн иж бүрэн цахим хурлын системийг аймгийн хэмжээнд 17 суманд хүлээлгэн өглөө. Ингэснээр хурал, зөвлөгөөнийг шуурхай зохион байгуулахад тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангагдаж, цаг үеийн шуурхай мэдээ мэдээлэл солилцох, түүнээс гарах шийдвэр түүний хэрэгжилт болон бусад ажил арга хэмжээ зохион байгуулахад цаг хугацаа, төсөв санхүү хэмнэх боломжийг бүрдүүллээ.

Онцгой байдлын чиглэлээр

Орон нутгийн кабелийн телевизээр “Пиротехникийн хэрэгслийг ашиглах үеийн аюулгүй байдал”, “Мөс цөмрөх аюулаас сэргийлье” “Орон байрны галын аюулгүй байдлыг хангая” сэдвүүдээр сэрэмжлүүлэг материал бэлтгэн 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлэхийн зэрэгцээ Гамшгаас хамгаалах улмын хяналтын байцаагч, ахмад Ц.Идэш, салааны захирагч, ахлах дэслэгч И.Балдандорж нар шинэ жилийн баяр амралтын өдрүүдэд галын аюулгүй байдлыг хангах талаар яриа, танилцуулга хийсэн.

Мөн Сайхан, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Хушаат, Сант сумдын Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудсанд “Пиротехникийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа” сэдэвт материал бэлтгэн байрлуулж иргэдэд хүргэсэн.

Удирдамжийн хүрээнд Онцгой байдлын үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт хяналт, шалгалтын явцад боловсруулсан нийт эрх зүйн баримт бичиг

ᠰᠢᠵᠡᠭᠡᠨ	ᠤᠴᠡᠭᠤᠠ ø àèäèòàí ä òàì ðàäáñан		ᠴᠣ ᠳᠡᠭᠡ		Áè÷ñýí ýᠳ᠔ ᠴᠵéí áè÷èäáàᠳèì ò						ᠮᠤᠰᠤᠨ ᠠᠨᠠᠶᠢ
	ᠠᠠᠢ ᠠ	ᠠᠡᠡ ᠣ ᠳᠣ	ᠡᠡᠳᠡᠵᠡᠨᠢ	ᠠᠳᠡᠡᠳᠣᠶᠡᠨᠠᠢ	ᠴᠠᠠ᠋᠋᠋᠋᠋᠋᠋	ì ýáýääýè	᠋᠋᠋᠋᠋᠋᠋᠋	Äjá ýèò	ᠠᠡᠡ᠋	ᠠᠴᠣᠳᠣ ᠠᠶᠢ ᠡ	
2019 оны 01-р сар	61	-	149	59	26	34	-	-	-	-	3

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан болзошгүй гал түймэр, гамшгаас сэргийлэх ухуулга сурталчилгааны материал бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн бөгөөд орон нутгийн кабелийн телевизээр-6 сонинд-1, FM радиогоор 3 удаа явуулсан.

2019 оны 1 дүгээр сард 14 удаагийн объектын гал түймэр гарсанаас 3 гал түймэр мэдээллээр ирж, гал түймрийн улмаас нийт 111,250,110 төгрөгийн хохирол учирсан.

Гал түймэр унтраах, аврах ангиуд 11 удаагийн объектын гал түймрийн дуудлагаар ажиллаж , 1 тасгийн хүчээр 10, ангийн хэмжээнд-1 удаагийн гал түймрийг нийт 49,7 тонн ус, 311,19 литр шатахуун зарцуулан унтрааж, гал түймрийн аюулаас аж ахуйн нэгж, байгууллагын 86,000,000 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Мэргэжлийн хяналтын чиглэлээр

Тус аймгийн Орхон, Мандал, Сайхан сумдад гарсан гахайн африкийн мялзан өвчний үед хэрэгжүүлэх түр зааврыг үндэслэн үхсэн гахайн сэг зэмийг устгах, хашаа байрны ариутгал халдваргүйжүүлэлт хийх явцад хяналт тавин ажиллалаа.

Тайлант хугацаанд үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулж, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл салбар, Онцгой байдлыг газрын Орхонтуул суман дахь Улсын нөөцийн цэгт 2018 оны ургацаас нөөцөлсөн үрийн улаанбуудайн үрнээс зохих журмын дагуу дээж авч шинжилгээнд хамруулан арга хэмжээ авсан. Мөн Хүдэр сумын иргэн С.Даваадорж нь зохих зөвшөөрөлгүйгээр 1ш гөрөөс агнасан зөрчлийг илрүүлж 150.0 төгрөгийн торгууль, 660.0 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж барагдуулан хууль бусаар агнасан гөрөөсийг улсын орлого болгож мөн ойгоос бэлтгэсэн модоо гарал үүслийн

гэрчилгээгүйгээр тээвэрлэсэн Алтанбулаг сумын иргэн Г.Золзодлхам, Сүхбаатар сумын иргэн Ж.Зоригтбаатар нарт ЗТХ-ийн холбогдох заалтаар нийт 100.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулан ажиллалаа.

Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 23 аж ахуйн нэгжийн 63 дээжинд 137 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 15 аж ахуйн нэгжийн 48 дээж 58 үзүүлэлтээр эерэг гарч нийт дээжийн 76.1 %-ийг эзэлсэн дүнтэй гарлаа.

Аймгийн хэмжээнд амбулаториор томуугийн тандалтын 3 дугаар долоо хоногийн эхний 4 өдрийн байдлаар 15.2 хувь, түргэн тусламжийн дуудлагын 43.5 хувийг томуу, томуу төст өвчин эзэлж, амьсгалын замын өвчлөлтэй хүүхэд 81.8 хувийг эзэлж байгаа тул аймгийн Засаг даргын захирамжаар хөл хорио тогтоох арга хэмжээ авч, аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон хүүхэд харах үйлчилгээг 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд хөл хорио тогтоож, багш нараас эргүүл томилон РС тоглоомын газар, дэлгүүр, олон нийтийн газраар сурагчдыг явуулахгүй байх, нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх тухай үүрэг чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар

Сүхбаатар, Жавхлант, Алтанбулаг, Сант, Мандал, Баянгол, Орхон сумдын 10 аж ахуйн нэгж, иргэний 3 хүнсний дэлгүүр, 3 минимаркет, 1 караоке баар, 1 цайны газар, 1 дэн буудал, 1 үсчний салоны үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Үс засах үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5160:2002”, “Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Зүүнбүрэн сумын “Алтан-Од” ХХК, Шаамар сумын иргэн Р.Шагдарсүрэнгийн ирүүлсэн зөгийн бал, Сүхбаатар сумын иргэн Ж.Батбилэгийн үйлдвэрлэсэн бяслагт бууз, Шаамар сумын иргэн Б.Алтанцэцэгийн үйлдвэрлэсэн даршилсан өргөст хэмх, икра, хүрэн манжингийн салат зэрэг бүтээгдэхүүнийг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит шинжлүүлж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өглөө. 2 өрхийн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж буй 1 нэрийн 2 бүтээгдэхүүний хаяг шошгыг хянаж холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах талаар зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Стандартын салбар сангаас 8 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 6 нэрийн 9 стандартын борлуулалт хийж, мэдээлэл аргагүйн зөвлөгөө өгсөн. Хэмжил зүйн лабораторийн захиалгын дагуу 4 нэрийн 4 стандартаар хангаж, хэмжилзүйн лабораториос эзэлхүүн хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын “ЖАСТ” ХХК-ий шатахуун түгээх газрын 1 түгээгүүрийн шингэн хэмжигчийг ээлжит баталгаажуулалтад хамруулж, Бугант тосгоны “НИК” ШТС-ын А-80 түгээрүүр эвдэрсэн, Алтанбулаг суманд “МТЧ” ХХК-ын А-92 түгээгүүр илүү шахалттай байна гэсэн 2 нэгжийн дуудлагын дагуу ажиллаж, шингэн хэмжигчийн шахалтыг шалган битүүмжлэлийн лац тавьж, механик хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын худалдааны газрын 31 жин шалган баталгаажуулж, “Ред хил Монголия” ХХК, ТЭД сангийн салбараас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2 автомашины жинг баталгаажуулах хийсэн. Мөн массын хэмжлийн төрлөөр барьцаалан зээлдүүлэх газрын 3, аймгийн музейн 1 электрон жинд шалгалт тохируулга хийж, цахилгаан хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын айл өрхийн 17 ш цахилгааны 1 фазын тоолуур шалган ээлжит бус баталгаажуулалт хийж, аймгийн МХГ-ын сорилтын лабораторийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 термометрыг шалган баталгаажууллаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

2018 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг боловсруулан сангийн яам, Статистикийн хэлтэст хүргүүлж, мэдээллийн самбар, Шилэн дансны цахим хуудсанд

байршуулаад байна. Аймгийн төсвийн гүйцэтгэлийн 12-р сарын мэдээгээр орон нутгийн төсвийн нийт орлого 18,8 тэрбум буюу 110,4 хувь, төсвийн зарлагын гүйцэтгэл 79,2 тэрбум буюу 97,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн байгууллагуудын 2019 оны төсвийн сар, улирлын хуваарийг байгууллага бүрээр төсвийн Фискал програмд шивж Сангийн яаманд хүргүүлэн зарцуулалтын эрхийг бүрэн татуулсан.

2018 оны жилийн эцсийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан гаргахтай холбоотойгоор 2018 онд олгосон санхүүжилтийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн тооцоог сум, байгууллагаар нь гарган яамдуудтай санхүүжилтийн тооцоог хийж, аж ахуйн нэгж, байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дүгээр сарын 30-ны байдлаар 30 хувьтай байна.

Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарт 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргах, төрийн сангийн дотоод хяналтын үнэлгээ болон 2019 оны төсөвтэй холбоотой мэдээлэл өгч, цаашид анхаарах асуудлуудын талаар үүрэг чиглэл өглөө.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	74.302.918.0	71.551.182.3	96.3
1.1	Орон нутгийн төсвийн орлого	16.880.163.8	16.042.025.1	95.0
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	13.093.499.9	11.723.638.7	89.5
	Сумдын төсвийн орлого	3.786.663.9	4.318.386.3	114.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	6.300.000.0	6.300.000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	42.897.531.6	42.897.531.6	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	3.407.672.1	3.407.672.1	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	2.761.970.3	2.761.970.3	100,0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	141.983.2	141.983.2	100.0
1,7	Төсөвт байгууллагын өөрийн орлого /сум хөгжүүлэх сан орсон/	1.913.597.0	1.277.544.0	66.8
	2. Орон нутгийн төсвийн нийт зарлага	74.302.918.0	66.847.681.6	90.0
	Орон нутгийн төсвийн нийт зарлага	74.302.918.0	66.847.681.6	90.0
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	10.402.886.0	9.470.489.7	91.0
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2.999.542.6	1.268.661.4	42.3
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	18.272.580.6	15.183.132.9	83.1
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	3.032.394.1	2.161.744.0	71.3
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	488.376.0	376.113.2	77.0
2.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2.225.637.2	1.473.676.4	66.2
	Халамжийн сан	8.523.244.7	8.061.846.9	94.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	3.729.704.8	2.837.443.3	76.1
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	273.223.8	272.309.1	99.7
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	40.070.270.9	38.582.485.7	96.3
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	2.557.637.9	2.342.912.0	91.6

3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		50.185.160.6	50.126.051.6	99.9
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4.360.741.8	4.301.632.8	98.6
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.860.629.1	1.860.629.1	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	120.385.1	120.385.1	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	317.595.1	317.595.1	100.0
	Хөрөнгө оруулалтын зардалд	1.422.648.9	1.422.648.9	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.425.919.1	1.425.919.1	100.0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1.422.648.9	1.422.648.9	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	3.270.2	3.270.2	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	39.987.274.4	39.987.274.4	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	2.550.596.2	2.550.596.2	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	42.537.870.5	42.537.870.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	21.630.935.2	21.630.935.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	10.990.658.5	10.990.658.5	100.0
	- Соёлын байгууллага	2.817.455.7	2.817.455.7	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	997.203.0	997.203.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	5.383.826.8	5.383.826.8	100.0
	- Газрын кадастрын байгууллага	365.526.0	365.526.0	100.0
	- Хүүхдийн байгууллага	352.265.3	352.265.3	100.0
4. Тусгай сангуудын зарлага		1.877.991.7	567.264.2	30.2
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.877.991.7	567.264.2	30.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018-XI	2018-XII	2018 - XII 2018 - XI
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 200	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 000	6 500	108.3
	Үхрийн мах /кг/	7 000	8 300	118.6
	Адууны мах /кг/	5 800	6 800	117.2
	Ямааны мах /кг/	5 500	6 000	109.1
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 500	1 800	120.0
	Сүү /савласан, л/	2 600	2 600	100.0

	Тараг /задгай, л/	1 600	2 000	125.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	100.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 000	100.0
	Лууван /кг/	1 200	1 200	100.0
	Манжин /кг/	1 200	1 200	100.0
	Байцаа /кг/	1 500	1 500	100.0
	Сонгино /кг/	1 500	1 500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
	2. ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 835	1 835	100.0
	Бензин А - 92	1 885	1 975	104.8
	Дизелийн түлш	2 375	2 375	100.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

“Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 11 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг хянаж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойн хүрээнд Гавьяат эдийн засагч, Ардын Их Хурлын депутат Д.Тангадыг урин аймгийн Засаг даргын Тамгын газар, Хилийн 0243 дугаар ангийн алба хаагчидтай уулзалт ярилцлагыг зохион байгууллаа.

Төрийн албаны тухай хуулийн сургалтыг Хилийн 0243 дугаар анги, Хилийн 0101 дүгээр анги, Онцгой байдлын газар, Биеийн тамир, спортын газарт тус тус зохион байгуулж, Авлигатай тэмцэх газартай хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчил, түүнийг зохицуулах хэрэгцээ” сэдэвт сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 132 хүнийг хамруулсан. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн программ ашиглалт, журмын өөрчлөлтийн талаарх эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, ном, гарын авлагаар хангах арга хэмжээ авсан бөгөөд 2018 оны ХАСХОМ гаргалтын явц аймгийн хэмжээнд 50 гаруй хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 623 холбогдогчтой, 1649,8 сая төгрөгийн хохиролтой, 779 гэмт хэрэг бүртгэгдэж 50 хэргээр буюу 6,9 хувиар урьд оны мөн үеэс өсч, гэмт хэргийн илрүүлэлт 55,7 хувьтай, 23337 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн нь 80 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 1 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 232 бичиж, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 180, лавлагаа 1 олгож үйлчиллээ.

1 дүгээр сард иргэний бүртгэлийн талаар:

- ✓ Төрсний бүртгэл – 217 /эрэгтэй-111, эмэгтэй-106/

- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 57
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 18
- ✓ Үрчлэлт - 4
- ✓ Эцэг тогтоолт – 67
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 11
- ✓ Нас баралт – 68
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 608
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 186
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 155
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 265
- ✓ Гадаад паспорт олголт – 107
- ✓ ОХУ-ын хавсралт - 2494
- ✓ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 184
- ✓ Хот доторх шилжилт хөдөлгөөн – 349 тус тус бүртгэгдсэн байна.

Архивын чиглэлээр

Архивын Ерөнхий газраас ирүүлсэн албан тоотын дагуу Хосгүй үнэт баримтанд оруулах 9 баримтын жагсаалтыг Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.

Баримтмыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар, Түшиг сумын ЗДТГ-ын хөмрөгийн 51 хадгаламжийн нэгжид эрдэс шинжилгээний техник боловсруулалтын ажлыг хийж, 7461 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн. Мөн хөмрөгийн 34 хадгаламжийн нэгжийн 4952 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 2488, хүний нэр 14267, газарзүй нэр 2400, байгууллагын нэр 2856-г шивж эх баримттай холбосон.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар-115 цаасан суурьтай баримтнаас 30, мастер хувиас 34, цалингийн тодорхойлолт 6, эхийн одонгийн лавлагаа 1, магадлагаа, тодорхойлолт 34-ийг гаргаж үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

2019 оны 1 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд 1-4 дэх жилдээ ажиллаж буй ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн залуу багш нарт бага насны хүүхэдтэй ажиллах сэтгэлзүйн эерэг хандлагыг бий болгон тэдэнд тулгамдаж буй арга зүй, дидактикийн зарим асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор багш нарын сургалтыг зохион байгуулж нийт 76 багш хамрагдсан. Сургалтаар 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн “Багшийн хөгжлийн тухай” хууль, багшийн ёс зүйн дүрэм, мэдээлэл харилцааны технологийг сургалтад ашиглах, тогтвортой хөгжлийн агуулгыг судлагдахуун бүрээр хэрэгжүүлэх боломж, гадаад хэлний хичээлд ашиглаж байгаа сургалтын аргуудыг бусад хичээлд хэрэгжүүлэх боломж, хөгжим, технологийн хичээлээр сурагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх, жендер ба хүний эрх, хүүхдийн хөгжил, хамгаалал сэдвүүдээр мэдээлэл, дадлага ажлуудыг хийгэн арга зүйн зөвлөмж өгсөн.

Аймгийн хэмжээнд амбулаториор томуугийн тандалтын 3 дугаар долоо хоногийн эхний 4 өдрийн байдлаар 15.2 хувь, түргэн тусламжийн дуудлагын 43.5 хувийг томуу төст өвчин эзэлж, амьсгалын замын өвчлөлтэй хүүхэд 81.8 хувийг эзэлж байгаа тул хөл хорио тогтоох арга хэмжээ авч, Аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудыг 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 01-нийг дуустал хугацаанд, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээг 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 08-ныг дуустал хугацаанд хөл хорио тогтоолоо.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр БСШУСЯ-аас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд аймгийн төв

болон сумдын сургуулиудын бага ангийн бүлэг бүрт ангийн номын санд зориулан 282,1 сая төгрөгийн 25834 ширхэг хүүхдийн ном нийлүүлэгдэж, хүлээлгэн өгсөн.

Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг эхлүүлж аймгийн Нэгдсэн музейн үзмэрийг тоолох ажил 46,5 хувьтай явагдаж байна.

ОХУ-ын Буриад улсын гавъяат дасгалжуулагч Д.Эрдэнэбатын нэрэмжит жү-до бөхийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж Хөдөлмөрийн баатар 1, гавъяат дасгалжуулагч 5, гавъяат тамирчин 6, Олон улсын хэмжээний мастер 10 гаруй, Спортын мастер 22, хот хөдөөгийн 25 байгууллагын 260 гаруй тамирчдыг Олон улсын 10 гаруй шүүгч шүүн явууллаа. Тэмцээнд эмэгтэй эрэгтэй нийт 14 жингийн 56 багц медалийн төлөө өрсөлдсөнөөс:

Г.Наранцэцэг -48 кг Алдар спорт хороо

Л.Сосорбарам -52 кг Баянхонгор

Л.Энхрийлэн -57 кг Сүлд Спорт хороо

Б.Ганхайч -63 кг Алдар спорт хороо

Ц.Батцэцэг -70 кг ТЕГ-ын Эрч спорт хороо

О.Мөнхцэцэг -78 кг Сүлд спорт хороо

Э.Гандиймаа +78 кг Хилчин спорт хороо

Э.Ариунболд -60 кг Алдар спорт хороо

Н.Мөнхбаяр -66 кг Женко клуб

Ц.Цогтбаатар -73 кг Сүлд спорт хороо

О.Ууганбаатар -81 кг Сүлд спорт хороо

Э.Мөнхжаргал -90кг Сүлд спорт хороо

Б.Серик -100 кг Сүлд спорт хороо

О.Цэцэнцэнгэл +100 кг ТЕГ-ын Эрч спорт хороо нар аваргалж алтан медалийн эзэд болсон.

Багийн тэмцээнд

1-р байр Сүлд спорт хороо / ШШГЕГ /

2-р байр Хилчин спорт хороо / ХХЕГ /

3-р байр Эрч спорт хороо / ТЕГ /

3-р байр Женко клуб

Шилдэг Эмэгтэй Баянхонгор аймгийн тамирчин Л.Сосорбарам 52 кг, Эрэгтэй Сүлд спорт хорооны тамирчин Э.Мөнхжаргал 90 кг, Ц.Цогтбаатар Сүлд спорт хороо, Б.Баасанжаргал / Хилчин спорт хороо / нар шалгарлаа.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2018 оны 12-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 745 байсан бол 147 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 43 ажлын байранд 32 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 84 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 776 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 1-р сарын байдлаар 15742 иргэнд 1,435,943,800 мянган төгрөгийг олгоод байна.Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 692 иргэнд 259,202.5 мянган төгрөг

-Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 890 иргэнд 60,224.8 мянган төгрөг

-Ахмад настны тусламж, хөнгөлөлт 21 иргэнд 7,973.0 мянган төгрөг

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 87 иргэнд 8,768.7 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмж 58 эхэд 2,112.2 мянган төгрөг

-Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 14 иргэнд 2,220.0 мянган төгрөг

-Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 4,943 иргэнд 683,300.0 мянган төгрөг

-Насны хишиг 3058 иргэнд 240,010.0 төгрөг

-Цалинтай ээж хөтөлбөр 3052 иргэнд 148,980.6 мянган төгрөг

-Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 339 өрхийн 1927 иргэнд 23,152.0 мянган төгрөг олгосон.

3.Эрүүл мэндийн талаар

Томуугийн тандалтын 3-р долоо хоногийн байдлаар аймгийн хэмжээнд амбулаториор 8270 үйлчлүүлсний 1411 буюу 17,1 хувь нь Томуу, томуу төст өвчин эзэлж байна. Томуу, томуу өвчинтэй нийт тохиолдлыг 73,3 хувь нь 15, үүнээс 53,7 хувийг 4 хүртэлх насныхан эзэлж байна. Томуу, томуу төст өвчний гаралт нэмэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын А/02 тоот тушаал гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

-Бүх шатны эрүүл мэндийн байгуулагуудыг уртасгасан цагаар орой 21 цаг хүртэл ажиллуулах

-Эрсдэлтэй бүлгийн хүн ам, 5 хүртэлх насны хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, 65 –аас дээш насны иргэдийг гэрийн эргэлтээр амбулаторийн үзлэг хийх

-Томуугийн сорьцыг тээвэрлэн тандалт хийх

-Томуугийн амбулаторийн үзлэгийн мэдээ болон хэвтэгсдийн дунд томуугийн тандалтыг хийн, тухай бүр зөвлөмж хүргүүлэх

-Эмнэлгийн хүүхдийн орны тоог нэмэгдүүлэх

-Иргэдийн Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгааг олон талт хэлбэрээр зохион байгуулан ажиллаж чиглэлийг өгч хяналт тавьж ажиллаж байна.

Орхон сумын Эрүүл мэндийн төвд эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт үнэлгээ хийж, амьгүй төрөлт, нярайн эндэглийг магадлан хэлэлцэх хурал, сургалтыг бүсчилсэн зохион байгуулж Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сум, Рашаант, Номгон тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга, эх баригч нарийн нийт 28 хүнийг хамруулсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 4 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлсэн. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ үзүүлж буй гэмт хэрэгт холбогдсон 8 хүүхдийг хяналтандаа авсан ба эрүүгийн хэргийн 2 материалтай танилцаж, хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хууль ёсны төлөөлөгч томилон ажлууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2019 оны ээлжит хурлаар 18 хүүхэд орсноос шинээр 3 хүүхдийн байнгын асаргааг тогтоож, 4 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлж, 11 хүүхдийн байнгын асаргааг тус тус сунгасан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2019 оны 1-р сард 34.4 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 1 дүгээр сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 35.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 103.7 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг тайлант сард 150 иргэд, даатгуулагчдад гарган үйлчил, Тэтгэврийн даатгалын сангаас 16510 тэтгэвэр авагчдад 67943.3 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 7662 хүнд 2923.66 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 308 хүнд 2350.80 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 559 хүнд 938.87 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2019 оны 01 дүгээр сард нийт 4 хурал хийж 352 хүнээс, 29 хүнийг цуцалж, 62 хүн шинээр тогтоолгосон, 268 хүн актаа

сунгуулсан байна. Сүхбаатар өртөөний нийт албан хаагчдад Засгийн газрын үйл ажиллагааны төрийн хөтөлбөрийг сурталчлах, иргэд даатгуулагчдад нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, холбогдох хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүдийг олон нийтэд танилцуулах, мэдээлэл зөвөлгөө өгөх сургалтыг зохион байгуулсан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

“Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртын хуваариалалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам”-ын 1-р хавсралт маягтын дагуу Мандал сумын “СББ”ХХК-иас 3000 тн спиртын захиалга авч, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүсэн.

2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Олон Улсын Адра төслийн байгууллагатай хамтран "Органик хөдөө аж ахуйн түншлэл" сургалт зохион байгуулсан. Тус сургалтад төрийн байгууллага, хоршоод, манай аймагт үйл ажиллагаа эрхэлдэг тусламжийн байгууллагууд, Дарханы хүргээлэнгийн төлөөлөл 100 гаран хүн хамрагдсан ач холбогдол өндөр сургалт болж өнгөрлөө. Энэхүү сургалтын үр дүнд Сэлэнгэ аймагт органик хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд чиглэсэн талуудын оролцоог тодорхойлж, хамтын баталгаажуулалтын тогтолцоог бий болгон хөгжүүлэх, органик хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх талаар 2019 онд хийх ажлын төлөвлөгөөгөө тохиролцлоо.

Дархан-Уул аймагт сар шинийн баярт зориулан зохион байгуулагддаг “Цагаан сар-2019” үзэсгэлэн худалдаанд манай аймгийн хоршоологчид амжилттай оролцон “Шилдэг стэндтэй оролцогч”-оор шалгарч, өргөмжлөлөөр шагнуулсан.

Санхүүгийн оролцоо ба бизнесийн хөгжил тойм Мерси Кор байгууллагатай хамтарч Сэлэнгэ аймгийн Nomads 2019 оны 1-р сарын 16-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “Эрчимжсэн мал ахуй өнөөгийн байдал”, “Махны зах зээлийн сүүлийн чиг хандлага, мал аж ахуй, газар тариалангийн сэтгэлгээг өөрчлөх” гэсэн сэдвүүдээр илтгэл тавьсан. Сум бүрээс малчид, хувиараа бизнес эрхлэгч нар оролцсон.

Хүнс Хөдөө аж ахуйн яаманд мал үржлийн тайлан явуудсан. Нийт малын тоо, цэвэр эрлийз малын тоо, цөм сүргийн малын ашиг шимийн үзүүлэлт, Үржилд бойжуулсан худалдаж авсан болон худалдсан малын тоо, хээлтүүлэгч малд аттестатчлал хийсэн дүн, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлсэн бог малын хээлтүүлэгчийн мэдээ, ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн мэдээ, аймгийн мал хээлтүүлгийн мэдээ, төл бойжилтын мэдээ, зүй бус хорогдлын мэдээ, үржилд худалдан авах малын захиалга, үржилд худалдах малын захиалга, үхэр сүрэгт ангилалт хийсэн дүн, хонин сүрэгт ангилалт хийсэн дүн зэрэг тайлан мэдээ гаргаж ХХААХҮЯаманд хүргүүлсэн.

Сүхбаатар суманд орон нутгаас нийлүүлэгдэн худалдааны төвүүдээр борлуулагдаж буй мал, амьтны гаралтай мах махан бүдээгдэхүүний дээжийг авч стандарт арга зүйн дагуу шинжилгээг хийж ариун цэврийн гэрчилгээ олгосон. Үүнд: адууны 900 кг махны дээж, 7200 кг үхрийн махны 48 дээж, 1700 кг хонины махны 68 дээж, 200 кг ямааны 10 дээж, 140 кг гахайн махны 2 дээжид шинжилгээг хийлээ.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Сүхбаатар, Сайхан, Мандал, Алтанбулаг, Шаамар, Хүдэр сумдын 1:1000 масштабтай байрзүйн зурганд баяжуулалт хийж, 2018 онд аймгийн хэмжээнд нийт 122136.85 га талбайд хохирол учирч, 4448.36 га талбайд газар хамгаалах арга хэмжээ авсан байна. Аймгийн хэмжээнд 2018 онд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд 57 удаагийн хяналт шалгалтаар 314 зөрчил илэрсэн байна. Газрын маргаан тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх судалгаа, түүний талаар авсан арга хэмжээг аймгийн хэмжээнд нэгтгэж дуусгасан. 2018 онд аймгийн хэмжээнд 54 зөрчил маргаан бүртгэгдсэнээс эзэмших 12, өмчлөх 16, хилийн цэсийн маргаан 8, ашиглах 18

маргаан тус тус гарсан байна. Үүнээс шийдвэрлэгдсэн эзэмших 8, өмчлөх 13, хилийн цэсийн маргаан 4, ашиглах 18 байна.

“Карголанд” ХХК-ий Шаамар сумын Дулаанхан тосгонд 2019 онд үргэлжлэн хийгдэж буй 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажилд хяналт хийсэн. Мөн “Мэргэн дэнзэн” ХХК гүйцэтгэж буй Алтанбулаг суманд 2019 онд үргэлжлэн хийгдэж буй 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажилд энэ сард 2 удаа хяналт хийж, галын аваарын хаалгыг зургийн дагуу хийх. Уурын зуухны агааржуулалтын системийг зургийн дагуу хийх зэрэг шаардлагуудыг тавьж ажилласан. Норовхан” ХХК Сүхбаатар сум Нэгдсэн эмнэлэгийн микробиологийн тасгийн засварын ажилд хяналт хийж ажилласан.

Барилгын хөгжлийн төвөөс барилгын суурь судалгааны ажлын хүрээнд инженер техникийн ажилтнууд болон мэргэжилтэй ажилчдын эрэлт нийлүүлэлтийг тодорхойлох судалгааг Сэлэнгэ аймгийн хэмжээнд гаргахаар сумдын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлэн ажиллаж байна.

2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын захиалагчаас ирүүлсэн 11 зураг төсвийн дагуу Үнэлгээний хороо, ажлын хэсэг байгуулах шатандаа байна.

Долоо. Байгаль орчин

2019 оны 01 дүгээр сарын 03, 07, 12, 13-ны өдрүүдэд зарим сумдын нутгаар 0,0-1,0 мм цас орсон. Бусад хугацаанд цас ороогүй. Бүх сумдын нутгаар 0-10 см зузаан цасан бүрхүүл тогтсон бол хамгийн их нь Бугантад 10 см, хамгийн бага нь Мандал суманд 0 см цасан бүрхүүлийн зузаантай байна. Ихэнх хугацаанд салхи баруун болон баруун хойноос 4-9 м/сек байв.

Ихэнх хугацаанд агаарын температур шөнөдөө 20-25 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байв. 1-р арав хоногийн дунд үе хүртэл агаарын температур шөнөдөө 29-34 градус, өдөртөө 20-25 градус хүйтэн байлаа.

Сэлэнгэ аймгийн гол мөрний мөсний зузаан Сэлэнгэ мөрний мөсний зузаан Зүүнбүрэн сум орчмоор 92 өмнөх 10 хоногоос 15 см-ээр см, Сүхбаатар сум орчим 68 см өмнөх 10 хоногоос 1 см-ээр, Орхон голын мөсний зузаан Орхон сум орчим 91 см өмнөх 10 хоногоос 9 см-ээр, Сүхбаатар сум орчим 82 см өмнөх 10 хоногоос 3 см-ээр, Ерөө голын мөсний зузаан Ерөө сум орчим 88 см өмнөх 10 хоногоос 8 см-ээр, Дулаанхан орчим 84 см өмнөх 10 хоногоос 7 см-ээр, Хүдэр голын мөсний зузаан Хүдэр сум орчим 71 см өмнөх 10 хоногоос 6 см-ээр, Зэлтэр голын мөсний зузаан Түшиг сум орчим 81 см өмнөх 10 хоногоос 5 см-ээр, Хараа голын мөсний зузаан Баянгол сум орчим 62 см өмнөх 10 хоногоос 3 см-ээр тус тус нэмэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын 1-р сарын хоёрдугаар арав хоногийн ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.011 мг/м³, хамгийн их нь 0.017 мг/м³, азотын давхар ислийн дундаж агууламж 0.036 мг/м³, хамгийн их нь 0.058 мг/м³, нийт тоосны дундаж агууламж 0.110 мг/м³, хамгийн их нь 0.408 мг/м³, РМ10 тоосонцорын хэмжээ хүлцэх агууламжаас даваагүй бөгөөд агаар болон хөрсөн дээрхи цацрагийн түвшин фон түвшнээс даваагүй байна.

“Ойн тухай хууль, тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах зарим зүйлсийн талаар” сэдэвт сургалтыг 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Хүдэр сумын ИТХ-ын төлөөлөгчид болон аж ахуйн нэгж, байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн гишүүд нийт 24 хүнийг хамруулан зохион байгууллаа.

Найм.Сум орон нутгийн талаар

Баянгол сум:

Монгол Улсад ардчилсан Үндсэн хуулийг мөрдөж эхэлсний 27 жилийг ойг тохиолдуулан тухайн үед анх сонгогдон ажиллаж байсан анхны ИТХ-ын төлөөлөгчид болон ЗДТГ-ын ажилтан албан хаагч нийт 20 гаруй ахмад ажилтныг урьж залуу

төрийн албан хаагчидтай уулзалт ярилцлагыг зохион байгуулж, сумын төр, төсвийн байгууллагын 78 ажилтан хамруулж, дээрх ахмадуудад хүндэтгэл үзүүллээ. Мөн Үндсэн хуулийн өдөрт зориулсан шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан сумын хэмжээний ахмад настны судалгааг гаргаж, нийт 467 ахмад нхастанг 142 аж ахуйн нэгжид хуваарилан хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Энэ сарын 5-нд Дуулах цаг дуун цэнгүүн арга хэмжээг, 10-нд “Эмэгтэйчүүдийн бүтээлч цаг” арга хэмжээг зохион байгуулж гар урлаач эмэгтэйчүүдийг дэмжин “Цагаан эр-2019” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төвөөс амбулаториор 578 иргэнийг үзлэгт хамруулж, 116 иргэнийг онош тодруулахаар дээд шатлалын эмнэлэгт илгээж, хүлээн авах хэсгээр 368 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн.

Булган аймгийн төвд 2019 оны 1-р сарын 10-нд гарсан гахайн африкийн мялзэн өвчин илэрч оношлогдсон тухай мэдээллийг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсгийг томилж, сумын хэмжээний гахайн аж ахуй эрхлэгч өрх, иргэн, гахайны судалгааг гаргаж, тандалт үзлэг, ариутгалыг зохион байгуулж, сэрэмжлүүлэг мэдээллийн хүргэн ажиллаж байна.

Сумын удирдлага өвөлжилтийн байдалтай танилцаж малчин өрхүүдээр ажиллалаа.

Ерөө сум:

Сумын ЗДТГ-ын албан хаагчдад дээд байгууллагаас ирсэн хугацаатай бичигт хяналт тавин ажиллаж, “Хариутай бичгийн хяналтын самбар”-ыг 7 хоног тус бүрээр гарган хөтөлж, мэдээ тайлан, хугацаатай бичгийн хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, “Үдэж цэгцэлье” аяныг байгууллагын хэмжээнд зохион байгуулж албан хаагч бүр 2018 оны баримт материалуудаа үдэж цэгцлэн архивт хүлээлгэн өглөө.

Монгол Улсад “Ардчилсан шинэ” Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, анхны үндсэн хууль батлалцсан тус сумын харъяат Монгол Улсын гавъяат механикжуулагч “Их-Шинэстэй” ХХК-ий захирал С.Ганболдод хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион ббайгуулж, иргэд, залуучуудын дунд сургалт хийснээс гадна “Спиртлээ биш-спортлог амьдарцгаая” уриан дор гар бөмбөгийн тэмцээнийг явууллаа.

2018 оны жилийн эцсийн мал тооллогоор гарсан мэдээгээр ХАА-1, ХАА-2, ХАА-3 мэдээг гаргаж статистикийн програмд шийвлээ. Сумын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 69322 толгой мал тоологдож, өнгөрсөн оныхоос 5680 толгойгоор өссөн дүнтэй байна.

Мөн үндэсний үйлдвэрт арьс, шир тушаасан 9 малчин өрхийн 16 ширхэг арьс ширний падааныг 1 дүгээр сарын 02-14 ны өдөр хөдөө аж ахуйн тасагт хүлээн авч нэгтгэн 1 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн ХХААГ-тт хүргүүлээ.

Сумын хэмжээнд гахай тоолуулсан 17 өрхөд багийн Засаг дарга нар, Лха-Чинбу ББН, Бадаан зүрх МЭҮН-тэй хамтран гахайн мялзэн өвчний талаар мэдээлэл өгсөн. Мөн Ерөө сумын нэгдсэн зар дээр гахайн мялзэн өвчний талаарх мэдээллийг тавьсан.

АМХГ-ын ХЧСХУБайцаагч н.Чинбатын хамт гахайн мялзэн өвчин гарсантай холбогдуулан худалдаа үйлчилгээний газруудад зөвлөмж гарын авлага тарааж, сар шинийн баяр болохтой холбогдуулан урдчилан сэргийлэх хяналт шалгалтыг томоохон үйл ажиллагаа явуулж буй 4 газарт хийж нийтдээ 39 нэр төрлийн 291 ширхэг 685,550 төгрөгний үнэ бүхий хадгалах хугацаа нь дууссан хүнсний бараа бүтээгдэхүүнийг устгалын комисстой хамт устгалд орууллаа.

“Хүүхэд хамгаалалд-Эцэг эхийн оролцоо” сэдэвт “Эцэг эхийн нэг өдөр” өртөөчилсэн сургалтыг зохион байгуулж 6 өртөөгөөр дамжуулан эцэг эх, асран хамгаалагч нарт сургалтын үнэлгээг танилцуулах, эко сургуулийн үнэлгээ хийлгэх, дасгал хөдөлгөөн хийлгэж чийрэгжүүлэх, цахим орчны зохисгүй хэрэглээ болон аюулын талаарх мэдлэг олгох-UNFRIEND хөдөлгөөнийг таниулах, “Хүчирхэг охид”

аппликэйшнийг танилцуулж бэлгийн хүчирхийлэл, халдлага дарамтаас урьдчилан сэргийлэх замаар хүчирхэгжүүлэх сонжоо бөглүүлэн зөвөлгөө өгөх, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуул эрхзүйн мэдлэг олгох, ухаалаг утасны зохистой хэрэглээний талаарх мэдлэг ойлголтыг өгөх зэрэг агуулга бүхий сургалтыг зохион байгуулан явууллаа. Сургалтад давхардсан тоогоор 452, дан тоогоор 170, /70%/ эцэг эх хамрагдан оролцсон. 30 багш 7 багт хуваагдан үйл ажиллагааг хамтран зохион байгуулан явууллаа. Сургалтын үеэр жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг халж хүүхэддээ хэлэхгүй байхыг хичээх 9 үг”, замын хөдөлгөөний аюулгүй байдал, санхүүгийн боловсрол олгох, нойр хүүхдийг ухаалаг болгодог, цүнхний жин, гэрийн даалгавар хийхийн ач холбогдол, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийн засаж болох хүмүүжлийн 8 алдааг таниулах, сургуулийн орчинд ухаалаг утас хэрэглэхгүй байх журам зэрэг мэдээллийг бэлтгэн тус тус 8 төрлийн боршуур болгон хэвлэж 170 эцэг эхэд 1238 ширхэг боршуурыг түгээж мэдлэг ойлголтыг давхар өглөө.

Сумын эрүүл мэндийн төв 1-р сард амбулаториор 356 хүнд үзлэг хийсэн. Стационариор 20 хүн хэвтүүлэн 225 ор хоног ашигласан. Сумын эмнэлэгт төрсөн эх -0, Нас баралт 3, эхийн эндэгдэл -1, Хорт хавдарын нас баралт -1, Осол гэмтлийн нас баралт -0, 0-15 насны хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг 100%-д хүргэж, тарилгат халдварт өвчин гаргалгүй ажиллаж байна. Жирэмсний хяналтанд 33 эх хяналтанд байгаа бөгөөд шинээр 5 эхийг хяналтанд авсан.

Томуу, томуу төст өвчний гаралт нэмэгдсэнтэй холбогдуулан Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын даргын 2019 оны 01 дүгээр сарын 11 ны А/02 тоот тушаалыг хэрэгжилтийг хангах зорилгоор Томуу, төст өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах “зорилгоор ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа.

ЭМТ-ийн даргын 2019 оны 01 сарын 12 ны өдрийн А/04 тоот уртасгасан цагаар ажиллуулах тухай тушаалаар эмч нарыг хуваарилан амралтын өдрүүдэд 10-16 цаг, ажлын өдрүүдэд ажлын өдрүүдэд 21 цаг хүртэл ажиллаж байна.

Зүүнбүрэн сүм:

2019 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг зохион байгуулж 1 дүгээр цэргийн бэлтгэл үүрэгтэн 192, 2 дугаар цэргийн бэлтгэл үүрэгтэн 481 хамрагдлаа.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 6, гэрлэлт 2, нас баралт 2, овог нэр өөрчлөлт 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 3, гэрлэлт 1, гэрлэлт цуцлалт 1, иргэний үнэмлэх олголтын 5, шилжин ирсэн 9, иргэнд тус тус бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Монгол Улсад анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдсаны 27 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд 2018 оны сумын аварга шалгаруулах шатрын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд нийт 10 шатар сонирхогчид оролцсоноос 1 дүгээр байранд Бэлчир 2 дугаар багийн иргэн Д.Хишигдорж, 2 дугаар байранд Бэлчир 2 дугаар багийн иргэн Б.Дэлгэржаргал, 3 дугаар байранд Жаргалант 1 дүгээр багийн иргэн Б.Баярсайхан, Эмэгтэйтөмөрчдаас 1 дүгээр байранд Мангирт 3 дугаар багийн иргэн О.Мөнхзул нар шалгарлаа. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийн тухай хуулийн иргэний бүртгэлтэй холбогдох заалтуудыг Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, 14 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчдад сурталчиллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт “Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой хэрэглэх нь” сэдэвт сургалтыг Сэлэнгэ бүсийн сургагч багш нар зохион байгууллаа.

Сурагчдын амралтын үеэр багш нарыг ажлын байранд хөгжүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”, “Тогтвортой хөгжлийн боловсролыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интергацчилах арга зүй” сэдвээр мэдээлэл хийлээ. “Цахим сургууль” зорилгын хүрээнд сургуулийн 20 анги танхимыг камержууллаа.

“Сургууль хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 24 багш, удирдлагууд Улаанбаатар хотын “Шинэ Эрин” ахлах сургууль, “Оюуны-Ундраа” цогцолбор сургуулиудтай танилцаж, туршлага арга зүйгээ солилцлоо.

Эрүүл мэндийн төв 26 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулатороор 360 иргэнд үзлэг хийж, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ. Амьсгалын замын халдварт өвчнөөр 0-5 насны 23 хүүхэд өвчлөн хэвтүүлэн эмчиллээ.

2019 онд арьс, ширний урамшуулалд хамрагдах 74 өрхийн 160 ширхэг баримтыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ.

2018 онд МЭҮН-н мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх малчин, мал бүхий өрхийн жагсаалтыг баг тус бүрээр гаргалаа. 2018 оны жилийн эцсийн мал тооллогоор 75710 толгой мал тоологдсоноос адуу 4228, үхэр 12393, хонь 32373, ямаа 26716 толгой тус тус тоологдлоо.

Сумын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн мал тэжээвэр амьтадын мал тооллогоны бүртгэл мэдээнд тулгуурлан 29 өрхийн 189 толгой гахайны судалгаа гаргаж, гахайн аж ахуй эрхлэгчдэд хандсан зөвлөмжийг, гахайн мялзан өвчинтэй тэмцэх зааварын хамт 80 гаруй иргэдэд сурталчилан ажиллаа.

Гахайн аж ахуй эрхлэгч 21 өрхийн 93 өрхийн гахайд мал эмнэлэг үржлийн нэгжүүдтэй хамтарсан үзлэг тандалт явууллаа.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд сум хөгжүүлэх сангийн программд нийт 66 зээлдэгчийн материалыг бүрэн шивж дуусгасан ба зээлийн үлдэгдэл 174.540.642 төгрөг байна.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын зөвлөлийн хурал 1 дүгээр сард 1 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 4 удаа байгуулж, цаг үеийн болон бусад асуудлуудыг хэлэлцлээ.

Энэ сард төрсний бүртгэл 5, шилжилт хөдөлгөөн 2, иргэний үнэмлэх олголт 11, гэрлэлтийн бүртгэл 1, шинээр иргэний үнэмлэх 1, сунгалт 3 иргэн, нийт 21 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Томуу, томуу төст өвчний дэгдэлт идэвхжих хандлагатай байгаа тул урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх албан даалгаврыг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, багш нар айл өрхүүдээр явж сурагчдад томуу томуу төст өвчний талаар зөвлөмж мэдээлэл өгч байгаагаас гадна нэмэлт гэрийн даалгаврыг өгч ажиллалаа. \

2019 онд сумын нийт төсвийн зарлага 1694,0 сая төгрөг байхаар иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлагдсан бөгөөд төсөвт зардлыг санхүүжих эх үүсвэр нь орон нутгийн санхүүгийн дэмжлэг 570,6 сая төгрөг, улсын төсвөөс улсын төсвөөс санхүүжих тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 988,8 сая төгрөг, орон нутгийн татварын орлого 49.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 53.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих 21.9 сая төгрөг, төсөвт газрын өөрийн орлого 1.0 сая төгрөг, дансны үлдэгдэл 9.0 сая төгрөг байхаар баталлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам” баталсан 153 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган 2018 онд 9 иргэнд 83,0 сая төгрөгийг олгохоор байсан боловч зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байсны улмаас 7 иргэнд, 68,0 сая төгрөгийн зээлийг олгосон. 2011-2014 онд сум хөгжүүлэх сангаас зээл аваад төлөөгүй иргэд шүүхийн байгууллагад шилжүүлсэн боловч хугацаандаа төлөлт хийгдээгүй тул энэ оны 1 дүгээр улиралд багтаан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэн өгч байна.

Сумын Засаг даргын баталсан хуваарийн дагуу онцгой комиссын гишүүд болон Засаг даргын Тамгын албан хаагчид хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7036171 тоот утсанд орон нутгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг тухай бүрт мэдээллэж ажилласан.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Бумбат 1 дүгээр багийн бумбат гудамжны нийт 20 өрхийн өвөлжилтийн байдалтай танилцаж, 12 дугаар сарын Жавхлантын мэдээ сонинг хүргэж, иргэдэд цаг үеийн мэдээллийг өгч ажилласан.

Мандал сүм:

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ой 2019 оны 01 сарын 13 өдрийг тохиолдуулан Үндсэн хуулийг сурталчилах иргэдэд сургалт мэдээлэл хийх ажлыг зохион байгуулан су үндсэн хуулийн үүсэл хөгжилийн талаар танилцуулага болон видеогоор ЗДТГ, Хэрх, Түнхэл захирагчийн албан 94 албан хаагчдад сургалт мэдээлэл хийлээ. Үндсэн хууль холбоотой танин мэдэхүйн асуулт бэлтгэн АХА тэмцээнийг зохион байгуулж, шинэ үндсэн хууль батлахад оролцож байсан АИХ-ын депататууд болон тухайн үед ажиллаж байсан ИТХ-ын төлөөлөгчдийн талаар мэдээлэл бэлтгэн танилцууллаа.

Хүүхдийн өөрийн сонирхол, оролцоонд тулгуулан, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, өөрийн чадвараа нээн илрүүлж хөгжүүлэх, сурлагын амжилтаа дээшлүүлэх нөхцөл боломжоор хангах зорилготой 4 төрлийн дугуйлан тогтмол өдрийн 3 ээлжээр хичээллэж байна.

“Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, зан үйлд нөлөөлөх 10 модуль сургалтыг гарцаарчилан 2 сар хүүхэдтэй ажиллаж дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж, сөрөг зан хэвшлийн засах, бие хүн болж төлөвшихөд нөлөөлөх замаар 2 гэр бүлийн, 2 асран хамгаалагч, 4 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хүүхдийн тусламжийн 108 утсанд 1901,1902 кодтой 2 кейст хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн хамтарсан багийн гишүүдтэйгээ хамтран 1822,1837,1838,1901,1902 кодтой 5 кейс дээр ажиллаж 5 гэр бүлийн, 8 асран хамгаалагч, 5 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Сэлэнгэ аймгийн “Алтан түрүү-2019” яруу найргийн 33 дахь удаагийн наадмыг энэ сарын 7-нд Мандал суманд амжилттай зохион байгууллаа. Наадмын шүүгчдээр Мандал сумын нийтийн номын сангийн захирал болон МЗЭ-ийн шагналт яруу найрагч, Сэлэнгэ аймгийн Алтан түрүү яруу найргийн наадмын 9 удаагийн тэргүүн шагналт, хойд бүсийн яруу найргийн наадмын 5 удаагийн шагналт, Баатарван Н.Наваан-юндэнгийн 110 жилийн ойн яруу найргийн наадмын дэд тэргүүн байрын шагналт, Сэлэнгэ аймгийн хайрын шүлгүүд наадмын тэргүүн шагналт зохиолч Т.Доржсүрэн, Г.Сэр-одын шагналт яруу найрагч, Сэлэнгэ аймгийн Алтан түрүү яруу найргийн наадмын хошой тэргүүн шагналт, хойд бүсийн яруу найргийн наадмын 4 удаагийн шагналт, Баатарван Н.Наваан юндэнгийн 110 жилийн ойн нэрэмжит яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт зохиолч Ч.Алтанхуяг, МЗЭ-ийн гишүүн, МЗЭ-ийн утга зохиолын төлөө шагналт, Тоншуул сэтгүүлийн хошой тэргүүн шагналт зохиолч Л.Банзрагч, Мандал сумын утга зохиолын нэгдлийн эрхлэгч яруу найрагч Б.Энхбаатар нар ажиллалаа. Тэмцээнд Сэлэнгэ аймгийн 21 яруу найрагч оролцож, 1-р байранд МЗЭ-ийн гишүүн, СЭлэнгэ аймгийн алтантүрүү наадмын тэргүүн шагналт, Баатарван Наваан-юндэнгийн 110 жилийн ойн яруу найргийн наадмын тусгай шагналт Б.Пүрэврэнцэн шалгарлаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай нийт 19 иргэний асуудлыг шийдвэрлэлээ.

Мандал суманд ойн санг гэрээгээр эзэмшдэг 30 нөхөрлөл, 23 аж ахуйн нэгжийн сумын Засаг даргатай байгуулсан гэрээ болон менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн дүгнэлтийг сумын ИТХ-д танилцуулсан бөгөөд, нийт 30 нөхөрлөл, 23 аж ахуйн нэгж байгууллага хамрагдан хангалттай сайн үнэлгээ авсан 2 нөхөрлөл 3 ААНБ, хангалттай үнэлгээ авсан 16 нөхөрлөл, 19 ААНБ, хангалтгүй үнэлгээ авсан 6 нөхөрлөл, 2 аж ахуйн нэгж байна. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичигийг 13 аж ахуйн нэгжид 658 м3, 48 иргэнд 367 м3 түлээний эрхийн бичиг олгож, 84 ширхэг гарал үүслийн гэрчилгээнд түлээ- 195 м3, хэрэглээ 715 м3 буюу нийт 910 м3 бичиж олгосон.

Аймгийн Засаг даргын “Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2019 оны 01-р сарын 14-ний өдрийн А/10 тоот захирамж, 2019 оны 01 сарын 15-ны 01 тоот албан даалгаврын дагуу гахайн Африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга

хэмжээ зохион байгуулж, малын эмч, багийн Засаг дарга, нийгмийн ажилтнууд 4 бүлэг болон хуваагдаж төвийн 6 баг болон Хэрх тосгонд ажиллаж, гахайн аж ахуй эрхлэгч 104 өрхөд сэрэмжлүүлэг, 1 өрхөд 70 гр /нийт 7280 гр/ Ни сор ариутгалын бодис олгосон. Энэ сарын 16-ны өдрийн 11:00 цагийн үед “Таван суварга” мал эмнэлэг 2-р багт тандалт судалгаагаар ажиллах үед Хайлаастын 98-ын б” тоотод оршин суугч Д.Базарсадын гахай үхсэн гэх мэдээллийн дагуу ХАА-н тасгийн малын эмч нар үзлэг хийж, цуснаас дээж авч Улсын Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид хүргүүлж, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори 17-ны өдрийн 19-389 тоот бүртгэлийн дугаартай шинжилгээний дүнгээр Гахайн африк мялзан өвчин болох нь батлагдсан. Үүнтэй холбогдуулан сумын Онцгой комиссын өргөтгөсөн хуралдааныг 18-ны 11:00 цагт Сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулан уг хурлаар Хорио цээрийн дэглэм тогтоохоор шийдвэрлэж, Сумын Засаг даргын 2018 оны 01 сарын 18-ны А/13 тоот “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамж гарч хорио цээрийн дэглэмд шилжсэн. “Холбоо толгой”, Хараа голын гүүр, Төмөр замын гарамд байнгын ариутгалын пост ажиллаж давхардсан тоогоор 108 албан хаагч ажиллаж байна. 2019 оны 01 сарын 25-ны байдлаар 17 өрхийн 326 гахай, гудамж талбайгаас олдсон үхсэн 30 гахайн сэгийг устгалд орууллаа.

Орхонтуул сум:

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилт, үр дүнг иргэдэд тайлагнах, сурталчлах ажлыг зохион байгуулж өрх бүрт мэдээлэл хүргэж, санал хүсэлтийг нь сонсож ажиллалаа. Сумын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлөөс сар шинийн баяр болохтой холбогдуулан суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, мухлагуудад Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Хүнсний тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалт хийж ажиллалаа.

Тайлант сард шинэ төрөлт-3, эцэг тогтоолт-2, нас баралт-4 бүртгэгдсэн байна. Шилжиж ирсэн-4 иргэнийн бүртгэлийг хийж ажилласан байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд “Шинэ төрсөн эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган 3 эх, хүүхдэд Засаг даргын гарын бэлэг, Дурсамж гардуулан өгсөн байна.

Сурагчдын амралтын хугацаанд багш нар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөө сайжруулах, цахим журналыг боловсролын мэдээллийн системд шивэх ажлын хүрээнд сургалтын менежер заавар, зөвлөгөө өгч сургалт мэдээлэл хэргэн ажиллаж байна. 2019 оны 01-р сарын 14-ны өдөр сумын сургууль дээр Боловсрол, соёл, урлагийн газрын баг ирж “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн сургалтыг Рашаант тосгоны ЕБСургуулийн бага ангийн 6 багш, захирал 1, сургалтын менежер 2, нягтлан бодогч 1, захирал, сургалтын менежер, бага ангийн багш 5, нягтлан бодогч 1, нийт 18 хүн тус сургалтанд хамрагдсан.

Гахайн африкийн мялзан өвчин гарсантай холбогдуулан гахайтай өрхүүдийн судалгааг нэг бүрчлэн нарийвчлан гаргаж, сумын хэмжээний нийт 28 өрхийн 359 гахайнд үзлэг шинжилгээ хийж, Сайхан сум дахь Гал унтраах, аврах 61 дүгээр ангид мэдээг өгч байна.

Сант сум:

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай Сэлэнгэ аймгийн засаг даргын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу гахайн аж ахуй эрхэлдэг 12 өрхийн 105 гахайд үзлэг хийж, гахайг байнгын байран маллагаатай байлгахыг зөвлөж сэрэмжлүүлэг гарын авлага тараасан байна. Халдварт өвчний сэрэмжлүүлэг мэдээллийг 5 дэлгүүр болон

багуудын мэдээллийн самбарт байршуулж, 01-р сарын 16-аас эхлэн өдөр бүрийн 16.00 цагт Сайхан сумын онцгой байдлын штабт мэдээ өгч ажиллаж байна.

Сумын Ивэн 1-р багийн иргэн З.Лхагвасүрэнгийн гахайд гахайн африкийн мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн илэрсэнтэй холбогдуулан сумын Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн хуралдаж аймгийн ОБГ-ын харьяа Сайхан сум дахь гал унтраах аврах ангийн дарга мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч ажилласан байна. Сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/09 тоот захирамжаар өвчний шинж тэмдэг илэрсэн голомтод хязгаарлалтын дэглэм тогтоож эргүүл хяналт ажиллуулсан.

2019.01.09-10 ны өдрүүдэд ADRA Монгол ОУБ-аас хэрэгжиж байгаа “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөл хөтөлбөрийн хүрээнд “Ногоочдын анхан шатны хоршоо байгуулах тухай”, “Хоршоо байгуулахын ач тус” сэдэвт сургалтанд Усан хээр, Сэлэнгэ тоотуу, Агрозаяа-Сант, Эсэргэнэ зэрэг хоршоодын гишүүд болон нийт 36 иргэн хамрагдсан байна.

Нийлэг уутыг хэрэглээнээс хасах тухай МУЗГ-ын 2018 оны 189 тоот тогтоолыг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад танилцуулж 18-04-334/14 тоот улсын байцаагчийн зөвлөмжийг өгч, сумын хог хаягдлын менежментийг сайжруулах хэм хэмжээний актыг боловсруулах төслийн хүрээнд хүрээнд ажлын хэсгийн шийдвэрээр хог хаягдлын норматив хэмжээг тогтоох, айл өрхөөс судалгаа авах ажлыг 18 өрх, 5 байгууллагад хийхээр зохион байгуулан ажиллаж байна.

Хууль бусаар мод бэлтгэсэн, тээвэрлэсэн 1 иргэний үйлдлийг илрүүлж ойн санд учруулсан хохирлыг 18-04-334/05 тоот актаар 222,300 төгрөг байхаар тогтоосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр, шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 27 жилийн ойг угтаж үндсэн хуулийн агуулга, бүтэц, ач холбогдлыг олон нийтэд сурталчилан таниулах, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор “Үндсэн хуулийн тухай ойлголт, Үндсэн хуулийн түүхэн замнал” сэдэвт сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж 41 төрийн албан хаагч, 23 иргэд хамрагдсан байна. Сум орон нутагт ажиллаж амьдарч байсан АИХ-ын депутатуудын намтар түүхийг өгүүлсэн мэдээлэл бүхий буланг Соёлын төв болон Иргэний танхимд байршуулсан байна. Мөн арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд Ивэн, Хушаат багийн хамтарсан “Нөхөрсөг спортын 4 төрөлт тэмцээн”-ийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээн гар бөмбөг, дартс, ширээний теннис, буухиа тэмцээн гэсэн 4 төрлөөр явагдаж нийт 14 багийн 148 тамирчид оролцож авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн байна.

“Миний Монгол” телевиз, ахмадын холбооноос зохион байгуулж байгаа “Буянтай буурлууд” цэнгүүн нэвтрүүлэгт сумын 15 ахмад настан оролцож төрж өсч, ажиллаж амьдарч байгаа нутгийнхаа талаар халуун дулаан яриа өрнүүллээ.

Сумын иргэдийн дунд хөдөлгөөний ач холбогдлыг сурталчилан таниулах, нийтийн цэнгээнт бүжгийн спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, иргэдийн гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх зорилгоор “Бүгдээрээ бүжиглэж сурцгаая” уриан дор “Бүжигчин хамт олон” байгууллага сурталчлах цэнгүүнийг Соёлын төвөөс зохион байгуулж 70 гаруй иргэн хамрагдаад байна.

Сумын ЕБС нь Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран Эцэг эх, сурагч багшийн гурвалсан харилцаа, Ажлын байран дах зөв харилцаа, Эрүүл ажлын байр, дасгал хөдөлгөөн, Сурагчдын эрсдэлтэй зан үйл, Сурагчдыг идэвхижүүлэх сэтгэлзүйн үндэс, Багшлах ажилдаа сурагчдын насны онцлогийг харгалзах нь сэдвүүдээр 2 хоногийн сургалтын ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 50 багш ажилчид хамрагдлаа. Мөн 1 дүгээр сарын 17 -18 ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Өсвөрийн бөхийн улсын аварга шалгаруулах” тэмцээнд тус сургуулийн 23 сурагч оролцон 4 мөнгө, 2 хүрэл медаль хүртлээ.

Сайхан сум:

Сумын төр, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нарын болон ЗДТГ-ын төрийн захиргааны албан хаагчдын 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, сумын

Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж, батлуулан, ололт амжилт, дутагдал, цаашид авч хэрэгжүүлбэл зохих ажил үүргээ дүгнэж, 2019 оны үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байна.

Монгол түмний үндэсний баяр “Цагаан сар”-ыг тохиолдуулан сум орон нутгаа суртчилан таниулах сумын 2018 оны ололт амжилт, сумаас төрөн гарсан баатрууд, гавьяат зүтгэлтнүүдээ алдаршуулах зорилгоор сар шинийн баярын өдөрт зориулсан “Бахархах түүхтэй Сайханчууд” телевизийн нэвтрүүлгийг зохион байгууллаа.

Монгол улсын Үндсэн хууль батлагдсаны 21 жилийн ойн хүрээнд ЗДТГазар болон төр төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдад Монгол улсын Үндсэн хууль, төрийн албаны тухай хуулийн сургалт зохион байгууллаа.

Улсын хэмжээнд цэргийн тоо бүртгэлийг 01-р сарын 07-20-ны хооронд зохион байгуулж байгаатай холбогдуулан сумын тоо бүртгэлийн ажлыг явууллаа.

Томуу, томуу төст өвчин ихсэж байгаатай холбогдуулан хүүхдийн тасгийн сувилалч нарын ээлжийг нэмэгдүүлэн, 4 ээлж болгон ажиллуулж байна. Мөн 0-5 насны хүүхдийн өвчлөлийн мэдээг өдөр бүр авч нэгтгэн, ЭМГ-т цаг тухай бүр мэдээллэж ажиллахаас гадна яаралтай тусламжийн дуудлаган дахь 0-5 насны хүүхдийн дуудлагын мэдээг тусгайлан авч, анхаарал татах асуудлуудыг дор бүрд нь өрхийн эмч нарт нь танилцуулж байгаа бөгөөд ЭМГ-ын даргын А/02 тоот тушаалын дагуу хуваарь гарган нэмэлт цагаар ажиллаж, 0-5 насны хүүхэд, өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүдийг гэрээр нь үзлэг, эргэлтийг хийж, шаардлагатай хүмүүсийг цаг алдалгүй хэвтүүлэн эмчлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч байна.

1 сарын байдлаар дээд шатлалд болон өөр эмнэлэгт 28 хүн илгээж, эмнэлэг хяналтын комиссын хурлаар 136 хүнийг оруулснаас ХЧА сунгалт-128 хүн, байнгын асаргааны сунгалт-2 хүн, акт сунгалт 4 хүн, ХЧА тогтоохоор 1 хүн, сувилалд сувилуулах-2 хүнийг оруулж, асуудлыг шийдвэрлэсэн байна.

Сумын Соёлын ордны хамт олон нь 2019 оныг “Уран бүтээлийн жил” болгон зарлаж тухайн ондоо тайз, дэлгэцийн шинэ шинэ уран бүтээлүүдийг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Үүний нэг болох 17-р Жарны урвуулагч хэмээх шороон гахай жилийн Сар шинийн баярыг угтан “Амар байна уу” телевизийн нэвтрүүлгийн бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Зураг авалтанд ажилтнууд 3 баг болж хуваагдан шагайгаар алаг мэлхий наадан тоглох бөгөөд баг тус бүр мэндчилгээ бэлтгэсэн байх, мөн “Хартай сарлаг” бүжиг, “Амартүвшин”, “Хаврын найраг”, “Таван эрдэнэ” дуунуудыг бэлтгэн хувь хувийн бэлтгэл хангаж ажиллаж байна. Тайлант сард баруун таван сумын хэмжээнд “Ахмадын дуун цэнгүүн” арга хэмжээ зохион байгуулагдлаа. УБ хотын ДБЭЧ-ын УГЗ Галсантогтох, МУГЖ Үенч, залуу дуучин Отгоночир нар хүрэлцэн ирж ая дуугаа өргөхийн зэрэгцээ ахмадуудын дунд дууны тэмцээн зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 300 орчим ахмадууд хүрэлцэн ирж нэгэн өдрийг дуу хуур бүжиг наадамдтай өнгөрүүллээ.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох МУЗГ-ын 2013.11.30-ны өдрийн 394-р тогтоолын дагуу сумын нийт 166 иргэний 13244 –н арьс, шир буюу 373 ширхэг паданыг ARIS программд шивж, холбогдох материалыг аймгийн ХХААГазар бичгээр болон файлаар хүргүүлсэн байна.

Гахайн мялзан өвчин Орхон суманд гарсантай холбогдуулан сумын Онцгой комиссыг шуурхай хуралдуулж, ажлын хэсэг томилон урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Хөх сэрхийн өвөр” мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч А.Цогтсайхан, Цөм сүрэг МЭҮН-ийн малын эмч Б.Чантуунар сумын хэмжээнд 18 айлын 585 м.кв гахайн байранд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мөн сумын худалдаа үйлчилгээний 18 аж ахуйн нэгж, байгууллагад гахайн гаралтай махан бүтээгдэхүүн худалдан борлуулж буй эсэхэд хяналт тавин ажиллаж, гахайн махан бүтээгдэхүүн худалдан борлуулж хэрэглэхгүй байх тал дээр зөвлөмж зөвөлгөө өгч ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлын төлөвлөгөөг гарган баталгаажуулан аймаг, сангийн яаманд хүргүүлэн

ажиллав. Энэ сард 11-р цэцэрлэгийн засварын ажил, Сум дундын эмнэлгийн бетонон авто замын ажил, гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажил, 24-р цэцэрлэгийн сантехник засварын ажлуудын зураг төсвийг “Бурхант орд” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн аваад байна.

Сүхбаатар сум

Сумын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн мал тэжээвэр амьтадын тооллогыг бүртгэл мэдээнд тулгуурлан малын эмч, багийн Засаг дарга нартай хамтран 4 багийн 44 өрхийн 357 толгой гахайд эрүүл мэндийн үзлэг тандалтыг хийж, Гахайн Африк мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж өгч, 446 м2 гахайн байранд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хүнсний зах, мах махан бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа хүнсний дэлгүүрүүдийн эрхлэгч, худалдагч нарт “ГАХАЙН АФРИК МЯЛЗАН” өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг өгч Хүнсний аюулгүй байдал, түүнтэй холбоотой гарч болох эрсдлүүдийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн мэргэжилийн хяналтын газар, Онцгой байдлын газар хамтран хүнсний худалдаа, нийтийн хоолны газруудад хяналт шалгалт хийж гахайн мах худалдан борлуулаж байсан 3 аж ахуй нэгж, 3 иргэний гахайн махнаас авсан дээжийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргэж өгч ажиллалаа.

Монгол улсын Ойн тухайн хуулийн 17.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 20-ны 86 тоот тогтоолыг үндэслэн, Сүхбаатар сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний модоор хангах гэрээг, Алтанбулаг, Түшиг, Ерөө, сумуудтай 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд Түшиг сумаас 15000 шоо метр, Ерөө сумаас 6500 шоо метр, Алтанбулаг сумаас 6500 шоо метр түлшний модыг тухайн сумдын нутаг дэвсгэрээс нийлүүлэхээр гэрээ байгуулсан. Энэ сарын 19-өөс Түшиг сумын Хар горхи чиглэлд мод өгч эхлээд байна.

Гудамж, талбайн, олон нийтийн газар архидан согтуурах, хулгайлах, танхай, дээрэм, гудамж талбайд согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах зорилгоор Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төр төсвийн 57-н аж ахуй нэгж, байгууллагуудыг хамруулан 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд “Нийтийн эргүүл”-д ажиллуулах захирамжийг гарган биелэлтийг ханган ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн “Эрч СӨХ”-ны кодтой хаалганууд эвдэрсэн гэсэн гомдлын дагуу нэг бүрчлэн байруудаар явж хаалгануудыг үзэн эвдэрсэн хаалгануудыг засварлуулах талаар гүйцэтгэсэн компани руу нь шаардлагыг хүргүүлэн ажиллалаа. 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нохой устгах ажлыг зохион байгуулахаар бичиг баримтыг боловсруулан тендер зарлахад бэлэн болоод байна.

Худалдаа, нийтийн хоолны 13 объектод хяналт шалгалт хийж, “Аян”, “Чандмань”, “Түмэн”, “Оч-Ир” минимаркетуудад хэрэглэх хугацаа дууссан 3 лт Три медведь пиво, Alpen gold шоколад, набор, контик печень зэрэг бүтээгдэхүүн худалдаалж байсныг газар дээр нь устгал хийж, Оч-Ир минимаркетын худалдаалж байсан ОХУ-аас оруулж ирсэн акцгүй 3л, 1л-ийн хайрцагтай, шилтэй нийт 19 ширхэг виног хурааж, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажиллалаа.

Сингапур улсын Erena Solutions LLC-ийн хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах тухай уулзалт ярилцлагад жижиг дунд үйлдвэр эрхлэгч 30 гаруй иргэнийг хамрууллаа.

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл сунгах хүсэлт ирүүлсэн Говь, Сутай хайрхан дэлгүүрт тамхи худалдаалах, Соёмбот билльямд зэрэг газруудад зөвшөөрөл олголоо.

Хүдэр сум:

Тайлант сард Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж шинээр баригдсан ЗДТГ-ын өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулах, Бахархах түүхтэй

Сэлэнгэчүүд нэвтрүүлгийг “Сэлэнгэ Шүтээн” ХХК–тай хамтран зохион байгуулах, Цагаан сар үзэсгэлэн худалдааг 2019.01.22-23-ны өдрүүдэд зохион байгуулах, Сар шинийн баярыг угтан сумын 9 алдартанг шалгаруулах, Нохой устгалын ажлыг зохион байгуулах, Ойн ангийн гарал, үүслийн эрхийн бичиг олголтын 2018 оны оны тайланг тус тус хэлэлцлээ. Мөн байгууллагын хурлыг 1 удаа зохион байгуулж албан хаагчдад цаг үетэй холбоотой мэдээлэл, хугацаатай үүрэг даалгаваруудыг өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Бахархах түүхтэй Сэлэнгэчүүд” нэвтрүүлгийг тус суманд 2019.01.19-ны өдөр ЗДТГазар, соёлын төвтэй хамтран сум орон нутгийн бахархал болсон 25 ахмад, дунд үеийн төлөөлөлийг оролцуулан зохион байгуулсан.

Үндсэн хуулийн ач холбогдол сэдвээр сумын төр төсвийн байгууллагын албан хаагч, иргэдийн дунд уулзалт хэлэлцүүлэгийг зохион байгуулж илтгэгчээр ТЗХЭЗМэргэжилтэн Л.Баяржавхлан сонголт тавьж чөлөөт ярилцлагыг хийлээ. Уг сургалтанд 36 төрийн албан хаагч, 25 иргэн хамрагдлаа.

Тарвагатай 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах Хогийн цэгийн ахуйн хог хаягдал болон үртэсийг аж ахуй нэгжтэй хамтран түрж цэвэрлэх ажлыг зохион байгуулан хяналт тавиж ажилласан. Сумын Засаг даргын 2019 оны 01 сарын 11-ны өдрийн А/ 03 дугаар захирамжаар “Сумын төвийн замын цасыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах тухай” бүх нийтийн цас цэвэрлэх ажилд хяналт тавиж ажилласан. Цас цэвэрлэгээний ажилд төр төсвийн 5 байгууллагын 40 албан хаагч, худалдаа үйлчилгээний 10 байгууллагын 35 иргэн, нийгмийн халамж үйлчилгээний газраас хүнс тэжээлийн хөнгөлөлт эдэлдэг 10 өрх айлын 15 иргэн оролцон сумын төвийн бетон хучилттай 0,8 км замын цасыг хамтран цэвэрлэсэн.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, Улаанбаатар хотын “Долоон болдог” ХХК, Дархан уул аймгийн “Цуурай-цо” ХХК, “Хүдэр төгөл” ХХК–аас 6000.0 төгрөгийн тавилга, эд хэрэгслийг нийлүүлж Багш хөгжлийн төв, Архив, бичиг хэрэг, бүлгүүд, бусад нэгжид хувиарлан угсарч байрлуулж ашигласан. Үүнд: багшийн ширээ 6ш багшийн шүүгээ 6ш сандал 20ш, эрхлэгчийн хувцасны шүүгээ 1ш, багш ажилтаны хувцасны шүүгээ 2ш, хүүхдийн сандал 20ш авч дотоод орчны тохижилтийг сайжруулсан. Мөн Бидний манлайлал, цэцэрлэг гэр бүл, бүлгүүдийн самбарыг туслах багш, багш хариуцан шинэчлэх ажлууд хүлээгдэж байна.

Цэцэрлэгийн мэдээллийн санд 220 хүүхэд бүртгэгдэн 198 хүүхэд 8 бүлэгт суралцаж байна. 2019 оны эхэнд 31-35 хүүхдийн ирцтэй байгаад багш нараар дамжуулан хүүхэд бүрийн эрүүл мэндийн талаар тандалт хийхэд 120 хүүхэд томуу томуу төст өвчлөлтэй гэрээр эмчлэгдэж байгаа судалгаа гарсан.

Тайлант сард ажил хайгч иргэнээр 12 иргэн бүртгүүлж ЗДТГазарт Нягтлан бодогч 1, Ойн анги ОНӨААТҮГазарт ойн техникч 1, ЕБС-д Сантехникч 1, Савхны үйлдвэрт туслах ажилтнаар 8 иргэн нийт 10 шинэ ажлын байр, 11 иргэнийг ажлын байрны зуучлаад байна.

Хүдэр сумын Засаг даргын захирамжын дагуу Мал, тэжээвэр амьтад, хашаа худаг, хүн амын жилийн эцсийн тооллогыг 2018 оны 12-р сарын 07-ноос 17-ны хооронд зохион байгууллаа. Тооллогыг Хөдөөгийн 2 хэсэг, Төвийн 12 хэсэгт хуваариалсан. Хэсэг бүрт 2 хүний бүрэлдэхүүнтэй. Хөдөөний хэсэгт жолоочийн хамт 3 хүний бүрэлдэхүүнтэй тооллого эхэлсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв нарын 30 албан хаагчид ажилласан. Хяналтын тоогоор Орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг 3 хүн хөдөөгөөр явсан. 2018 онд малчин өрх 94, мал бүхий өрх 256 тооллогдон бүртгэгдсэн.

2012,2013,2014,2015,2016, 2017 оны газар тариалангийн тайлан мэдээг үдэж хавтаслан архивд өглөө. Жимс жимсгэний мэдээг ХАА-5 маягтаар шивэж статистикийн газарт хүргүүлэв. 2018 оны мэдээ тайлангийн хавтаслаж, 2019 оны шинэ хавтас нээж ирсэн бичиг баримтын хавтас нээлээ. Сум хөгжүүлэх сангийн улирлын тайлан, мэдээлэл /Монгол банкинд иргэдийн мэдээлэл/сарын тайлан, дансны хуулга, ИТХ-ын тогтоол шийдвэрийг ХХАА-н газрын мэргэжилтэнд файлаар гаргаж хүргүүлэв. Пад пад тракторын үнэ нийт 2.700.000 төгрөг төлүүлж сум хөгжүүлэх

сангийн нийт 43 сая төгрөгний зээлийг төлүүлж төлөвлөгөөнөөс 17 сая төгрөг дутуу төлөгдсөн

Сэлэнгэ аймгийн БОАЖГазраас ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа даргатай ажлын хэсэг ирж Сумын ИТХурлын Төлөөлөгч болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгжүүдэд ойн тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Дээрх сургалтанд 11 ойн мэргэжлийн байгууллага, 8 нөхөрлөл, ИТХурлын төлөөлөгчид оролцсон болно.

Тайлант хугацаанд Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг 3 удаа хийж 45 иргэнд зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. Сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 03 ны өдрийн А/152 дугаар “Ойд үйл ажиллагааг зохион байгуулах тухай” захирамжаар Ойгоос мод бэлтгэх ажлыг 2018 оны 12 сарын 20-ны өдрөөр дуусгавар болгож ойн цэвэрлэгээний ажлыг хийж хүлээлгэж өгөх тухай албан мэдэгдэл гаргаж 22 аж ахуй нэгжид тараан ажилласан. Мод бэлтгэлийн аж ахуй нэгжийн доод агуулагаар явж 2 удаа хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтын явцад Зөрчлийн тухай хууль зөрчсөн Улаанбаатар хотын иргэнд зөрлийн тухай хуулиар арга хэмжээ авч ажилласан. Хууль бус мод бэлтгэл болон гадагш тээвэрлэлтийн явцад эргүүл шалгалтын ажлыг 3 удаа хийсэн. Хяналт шалгалтын явцад эзэн холбогдогч нь тодорхойгүй бэлтгэгдсэн 37 м3 нойтан нарсан гуалинг хуураж цагдаагийн гадна төвлөрүүлэн ажилласан.

Сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 03 ны өдрийн А/152 дугаар “Ойд үйл ажиллагааг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд Янгаахай, Зэрлэг, Амж нэртэй газруудад явж талбай тусгаарлалт болон эхлэлийн акт хийсэн 10 аж ахуй нэгжийн ойн цэвэрлэгээний ажлыг шалгаж ойн анги байгаль хамгаалагч нартай хамтран ажилласан. Тарвагатай 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах Хогийн цэгийн ахуйн хог хаягдал болон үртэсийг аж ахуй нэгжтэй хамтран түрж цэвэрлэх ажлыг зохион байгуулан хяналт тавиж ажилласан. Сумын Засаг даргын 2019 оны 01 сарын 11-ны өдрийн А/ 03 дугаар захирамжаар “ Сумын төвийн замын цасыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах тухай” бүх нийтийн цас цэвэрлэх ажилд хяналт тавиж ажилласан. Цас цэвэрлэгээний ажилд төр төсвийн 5 байгууллагын 40 албан хаагч, худалдаа үйлчилгээний 10 байгууллагын 35 иргэн, нийгмийн халамж үйлчилгээний газраас хүнс тэжээлийн хөнгөлөлт эдэлдэг 10 өрх айлын 15 иргэн оролцон сумын төвийн бетон хучилттай 0,8 км замын цасыг хамтран цэвэрлэсэн.

Хушаат сум:

Хушаат сумын "Мо Мо Агро" ХХК нь 2018 оны газар тариалангийн үйлдвэрлэлийн амжилтаараа улсад тэргүүлэн "Улсын аварга тариаланч хамт олон"-оор шалгарсныг УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог нар удирдлагууд хүрэлцэн ирж гардуулан өглөө.

Шинэ Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойг Хушаат суманд тэмдэглэн өнгөрүүлэх талаар ажлын төлөвлөгөөг төлөвлөн батлуулж Үндсэн хуулийн өдөрт зориулсан Үндсэн хуулийн видео сургалт, 1992 онд Шинэ Үндсэн хуулийг батлалцсан дахин эмхлэн байгуулагдсан Хушаат сумын анхны Засагдарга Х.Намсрайжав агсны талаар дурсамж, мэдээлэлийг 2 өдөр ажлын цагаар сумын ЗДТГ-ын үүдний танхимд явуулж нийтдээ 50 гаруй иргэнд сурталчиллаа. Арга хэмжээний хүрээнд Үндсэн хууль батлалцсан АИХ-ын депутат Х.Намсрайжав агсны нэрэмжит шатрын тэмцээнийг 5 дахь жилдээ зохион байгуулж, насанд хүрэгчдийн тэмцээнд шатрын спортын зэрэгтэй тамирчин Т.Гэрэлтуяа 1-р байр, шатрын спортын мастер С.Цэдэн-иш 2-р байр, Ц.Мөнхбүрэн 3-р байр, Ч.Адарсүрэн тусгай байранд шалгарсан ба ЕБС-ийн сурагчдын дунд уг тэмцээнийг явуулахаар төлөвлөөд байгаа ба тэмцээнийг Х.Намсрайжав агсны дүү, аймгийн аварга малчин Д.Алтансүхийн гэр бүл ивээн тэтгэлээ. Мөн Намсрайжав агсны хүндэтгэлийн буланг сумын Соёлын төвд 4 жилийн өмнөөс байгуулан баяжуулж иргэдэд хүргэж үйлчилж байгаа талаар мэдээлэл болон дурсамж мэдээлэлийг нийтэд “SelengeKhushaat” fb хаягаар сурталчиллаа.

Улсын бүртгэлийн тухай, Иргэний бүртгэлийн тухай хууль бусад холбогдох хууль журмын хүрээнд нотлох баримтуудыг үндэслэн дараахь бртгэлүүдийг хийлээ. Гэрлэлт 2, гэрлэлт цуцлуулсны 1, шилжин ирсний 4, өөр аймаг хотоос 5, насанд хүрэгч 2, 0-16 насны 3 хүүхдийн хамт , баг хооронд ,насанд хүрэгч 2, 0-16 насны 3 хүүхдийн хамт, нас барсны 1, цахим үнэмлэх дахин авах 2, биеийн давхцахгүй өгөгдлийн 9, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 3, газар өмчлөх эрхийн 2, иргэний үнэмлэх олголтын 8, нийт 33 бүртгэл хийж 3 гэрчилгээ бичиж олгов. Төрийн сан банкны орон нутгийн дансанд 40300, УБХ-ийн дансанд 180500 төгрөгийн орлого оруулсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх тасгаас “ Малын хулгайгаас урьдчилан сэргийлэх тухай” сургалтыг сумын Соёлын төвд зохион байгуулж нийт 54 малчин хамрагдлаа.

Сумын ИТХ-ын 12-р сарын 19-ны хуралдаанаар 2019 оны төсвийн орлого, зарлагыг 1496253,9 мянган төгрөгөөр баталсан. Тус тогтоолд орон нутгийн орлогыг 62226,0 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 536121,7 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг 840067,0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтыг 57839,2 мянган төгрөгөөр тус тус батлуулж ажилласан. Үүний дагуу сумын Засаг даргын 2019 оны 01-р сарын 10-ны өдрийн А/04 тоот захирамжаар төсвийн байгууллагуудын сар, улирлын хуваарийг батлуулан аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан.

Сумын хэмжээнд нийт 83517 толгой мал тоологдсон байна. Үүнд адуу -3405, үхэр-11825, хонь -39038, ямаа -29249 толгой мал тус тус тоологдсон байна. 2017 оны малын тоотой харьцуулвал адуу- 428, үхэр- 1926, хонь-3283, ямаа-4892, нийт 10529 толгой малаар өссөү үзүүлэлттэй байна. Төл бойжилтын мэдээ:Сумын хэмжээнд нийт гарсан төл- 31185. Үүнээс: унага – 719, тугал -3657, хурга -16818, ишиг -9991, нийт 156 төл мал хорогдож 31029 төл эсэн мэнд бойжиж байна. Том малын зүй бус хорогдол: Сумын хэмжээнд нийт 84 мал хорогдсон байна. Үүнээс адуу -14, үхэр -30, хонь -19, ямаа -21Хүн амын мэдээ: Сумын хэмжээнд нийт 2075 хүн тооллогод хамрагдсан байна. Үүнээс гадаадад оршин суугаа 9 хүн, 0-4 настай 228, 5-9 настай 249, 10-14 хастай 176, 15-19 настай 178, 20-24 настай 156, 25-29 настай 136, 30-34 настай 156, 35-39 настай 183, 40-44 настай 158, 45-49 настай 148, 50-54 настай 99, 55-59 настай 79, 60-64 настай 55, 65-69 настай 35, 70-74 настай 18, 75-79 настай 15, 80-84 настай 4, 85-89 настай 2 тус тус тоологод хамрагдсан байна.

Сумын Соёлын төвөөс “Би жингээ хасмаар байна” хөдөлгөөнт аэробекийн сургалтыг хичээллүүлж нийт 8 иргэн хамрагдлаа. Улсын хэмжээнд музейн тооллого болохтой холбогдуулан бэлтгэл ажлаа хангаж байна. Номын сангаас цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Чанга уншлага” зохион байгуулж нийтдээ 82 иргэнд ном хэвлэлээр үйлчиллээ.

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Их эмч Н.Энхтуяа, НЭМА-С.Хашдарь нар хамтран цэцэрлэгийн 18 хүүхэд болон нийт багш нарт үзлэг хийж, гарын авлага зөвлөмж тарааж, зөвлөгөө өгч, хүүхдүүдийг витаминаар дархлааг нь дэмжлээ.

ЭМТ-ийн Ор хоног 118, эмнэлэгт хэвтсэн 15, Эмнэлгээс гарсан 16, Үзлэгийн тоо бүгд 167 үүнээс , амбулатори 130, урьдчилан сэргийлэх 37, идэвхитэй хяналт 10, хяналтанд байгаа жирэмсэн 15, халдварт бус өвчин 78, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 205, Д-амин дэм уусан хүүхэд 32, А-амин дэм уусан хүүхэд 205, олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн хүүхэд, түргэн тусламжийн дуудлага 67, үүнээс алсын дуудлага 9, Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 30, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 5, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 23, элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 10 иргэн байна.

Орон нутгуудад гахайн мялзан өвчин гарсан болон томуу томуу төст өвчин ихээр гарч байгаатай холбогдуулан сумын онцгой комисс хуралдан эргүүл шалгалт хийхажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Гахай аж ахуй эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдэд “Гахайн африкийн мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж,

сэрэмжлүүлэг, гарын авлагаар хангаж гахайн байрыг ариутгал халдваргүйжүүлэлт хийж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

Шаамар сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас 2019 оныг “Хариуцлагын жил” болгон зарлаж, төрийн байгууллагуудын албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйн харилцааг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд өнгөрсөн оны орон нутгийн хэмжээнд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн тайлан мэдээ, судалгаа, нэгтгэлүүдийг баримтжуулан архивлах ажлыг зохион байгууллаа.

Улс орон даяар явагдаж буй цэргийн бүртгэлийн ажлыг суманд зохион байгуулж, холбогдох мэдээг аймгийн Цэргийн штабт хүргүүлсэн.

Монгол Улсад Ардчилсан Үндсэн хууль батлагдаж мөрдөж эхэлсний 27 жилийн ойн арга хэмжээний хүрээнд фото зурган самбарыг сумын ЗДТГ-т байршуулж, иргэдэд сурталчлах арга хэмжээ авч, 2-р багийн Засаг даргын ивээл дор сумын Сурын холбоотой хамтран төр төсвийн байгууллага, иргэдийн дунд сурын харваан тэмцээнийг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” 01 тоот албан даалгаврын дагуу сумын Засаг даргын захирамжаар “Гахайн африкийн мялган өвчин”-өөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажлын хэсгийг томилж, гахайн аж ахуй эрхлэгч иргэдийн байршлын зураглалыг гарган ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгууллаа.

Орон нутгийн малчин, мал бүхий иргэдээс дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн арьс, ширний урамшуулалд хамрагдах 74 иргэний материалыг холбогдох байгууллагад хүргүүллээ.

Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, сар шинийн баярт зориулсан үзэсгэлэн худалдааг 1-р сарын 14, 15-нд зохион байгуулж, иргэд 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчиллээ.

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр төллөх насны 10601 толгой хээлтэгч тоологдсоноос 1-р сарын 25-ны байдлаар 90 толгой мал төллөж, төл бойжилт 100 хувьтай байна.

БОЛОВСРУУЛСАН:

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА**

Ө.СУВДАА